

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр: "МАТЕРИАЛИМПЭКС" ХК

Хаяг, утас: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4-р хороо, Нарны зам 16/5, өөрийн байр. Утас: 70079924, 96051933, 365149

Хурал хуралдах огноо, цаг, газар: 2015 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 10:30 цагаас компанийн байрандаа.

Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 10 тоот тогтоол.

Олон нийтэд зарлах огноо: 2015.02.13 ба 2015.02.27-ны өдрүүд.

Бүртгэх өдөр: 2015 оны 2 дугаар сарын 23-ны өдөр


Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо:

___ 2015.02.13-ны өдөр ___

Хүргүүлсэн огноо: 2015.02.12.

Хурлын баримт бичгийн хуудасны тоо: 7 ширхэг, 9 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ

КОМИССЫН ДАРГА:  /Г.АЮУШМАА/

2015 оны 02 дугаар сарын 11-ний өдөр

ХҮЛЭЭН АВСАН:

БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН: _____ / _____ /

_____ оны _____ сарын _____ -ны өдөр



“МАТЕРИАЛИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 02 сарын 09

Дугаар 10

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 64 дүгээр зүйлийн 64.2, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах хорооны 2012 оны 34 тоот тогтоол, Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Материалимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 10:30 цагт тус компанийн хурлын танхимд хуралдуулсугай.
2. “Материалимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
 - Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх
 - Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх, батлах
 - ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх, батлах
 - Компанийн хөндлөнгийн Аудитын байгууллагыг томилох, түүнтэй гэрээ байгуулах этгээдийг томилох
 - Ногдол ашиг хуваарилах тухай
 - Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найрууллыг батлах зэрэг болно.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 2 дугаар сарын 23-ны өдрөөр тогтоосугай.
4. Ээлжит хурлын мэдэгдлийг хавсралт материалын хамт 2015 оны 2 дугаар сарын 12-ны дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржид, 2015 оны 2 дугаар сарын 14, 28-ны өдрүүдийн дотор өдөр тутмын 2-оос доошгүй сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг нэг телевиз, Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар тус тус дамжуулан нийтэд мэдээллэх, брокер дилерийн компаниудад зарыг хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Лхагвачулуунд даалгасугай.
5. Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт №01-ээр баталсугай.

6. Саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчийн санал авах хуудасны агуулгыг Хавсралт №02-оор баталсугай.
7. Саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2014 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 17:00 цагаар тогтоосугай.
8. Компанийн ээлжит хурлыг удирдах, зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн дарга Г.Аюушмаа, комиссын гишүүдэд ТУЗ-ийн гишүүн В.Ойдов, Т.Мөнхжаргал нарыг тус тус томилсугай.
9. Хурлын тооллогын комиссын даргаар П.Баатарцэрэн /РД: ЧС86112912/, гишүүдэд Л.Нямдулам /РД: ЧА81101808/, Д.Баатардорж /РД: СЭ91061817/ нарыг тус тус томилсугай.
10. Хурлын бэлтгэлийг хууль, журмын дагуу сайтар зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.АЮУШМАА

ТУЗ-ийн 2015 оны 02 сарын 09-ний өдрийн

10 тоот тогтоолын Хавсралт №01

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД БЭЛТГЭХ ЯВЦАД ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол №10 /хавсралтуудын хамт/
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг, дараалал
3. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлт
4. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлт
5. 2015 оны бизнес төлөвлөгөө
6. Компанийн дүрэм
7. Санхүүгийн тайлан тэнцлийн хураангуй зэрэг болно.

Жич: Бусад шаардлагатай мэдээллийг компанийн байранд биечлэн ирж болон 7007-9924, 9605-1933, 365149 дугаарын утсаар холбогдон танилцаж болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.АЮУШМАА

ТУЗ-ийн 2015 оны 02 сарын 09-ний өдрийн
10 тоот тогтоолын Хавсралт №02

САНАЛЫН ЭРХ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
САНАЛ АВАХ ХУУДАСНЫ АГУУЛГА

Хурал 2015 оны 04 сарын 08-ны өдрийн 10:30 цагт компанийн хурлын танхимд болно.

Хувьцаа эзэмшигчийн эцгийн нэр:

Өөрийн нэр:

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар:

Регистрийн дугаар:

Санал өгөх хувьцааны тоо:

Бүртгэсэн /Үнэт цаасны компанийн нэр/:

Брокерийн эцгийн нэр:

Өөрийн нэр:

Д/д	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх			
2	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх, батлах			
3	Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэж батлах			
4	Компанийн хөндлөнгийн аудитын байгууллагыг томилох, түүнтэй гэрээ байгуулах этгээдийг томилох			
5	Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг батлах			

Санамж 1: ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгоно. Энэ аргыг хэрэглэхэд энгийн хувьцаа тус бүр сонгогдох гишүүдийн тоотой тэнцэх саналын эрхтэй байх бөгөөд хувь нийлүүлэгч нь өөрийн хувьцаанд ногдох саналаа бүгдийг нь нэг хүнд, эсвэл хэд хэдэн хүнд хуваан өгөх эрхтэй.

Нэр дэвшигч бүрт өгсөн саналын тооны нийлбэр тухайн хувьцаа эзэмшигчийн саналын эрхийн тооны нийт дүнгээс илүүгүй байх бөгөөд саналын эрхийн тооны нийт дүн нь тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жнь: Та 100 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг гэвэл таны өгөх эрхийн тоо ТУЗ-д $11 \cdot 100 = 1100$ ширхэг байна. Таны нэр дэвшигч бүрт өгсөн саналын тооны нийлбэр нь таны санал өгөх

эрхийн нийт тооноос илүү байж болохгүй. Хэрэв илүү гарсан тохиолдолд таны саналын хуудас хүчингүй болно гэдгийг анхаарна уу!

Санамж 2: Санал авах хуудсыг засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно. Саналын хуудасны хуудас бүрийн доор гарын үсгээ зурна уу.

Жич: Хэрэв та хуралд биечлэн оролцох боломжгүй бол өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг оролцуулах буюу 2015 оны 04 сарын 08-ны дотор бөглөсөн саналын хуудсаа харъяа Үнэт цаасны компанидаа хүргүүлж, саналаа өгч болно.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаар "Материалимпэкс" ХК-ийн төв байранд биечлэн ирж авах буюу 70079924, 96051933 утсаар лавлаж болно.

Брокер /гарын үсэг/

Хувьцаа эзэмшигч /гарын үсэг/

Тооллогын комиссын бөглөх хэсэг:

1. Саналыг хуудсыг хүчинтэйд тооцов.
2. Саналын хуудсыг хүчингүйд тооцов. Шалтгаан нь:

1
ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА:

П.БААТАРЦЭРЭН

ГИШҮҮД:

Д.БААТАРДОРЖ

Л.НЯМДУЛАМ



“МАТЕРИАЛИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 02 сарын 09

Дугаар 09

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 46, 47, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, компанийн дүрмийн 10 дугаар зүйлүүдэд тус тус заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Материалимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд 2015 онд ногдол ашиг хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2015 оны 02 сарын 24-ний өдрөөр, ногдол ашиг төлөх сүүлийн өдрийг 2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тус тус тогтоосугай.
4. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг ТУЗ-ийн цалин урамшууллын хорооны дарга Д.Тунгалагт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.АЮУШМАА



МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК

Нягтлан бодох бүртгэл-Аудит, Баталгаажуулалт, Аутсорсингийн үйлчилгээ, Бизнесийн зөвлөгөө өгөх

2015 он 02 дүгээр сарын 03 өдөр

Дугаар № 144

Монгол улс Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг
И-Мэйл: odonchimegt@cpa.mn
Misheelod@yahoo.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“МАТЕРИАЛИМПЕКС” ХК-ИЙН ЗАХИРАЛ Б.ЗОРИГ Танаа

Бид “Материалимпекс” ХХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон мэдэгдэхүйц нягтлан бодох бүртгэлийн бодлого, тодруулгуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх замаар залилан, алдааны улмаас илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах, үүсч болох материаллаг буруу үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлагууд багтана.

Аудиторын үүрэг хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах нь бидний үүрэг юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг фиднээс шаарддаг.

Цар хүрээ

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна. Тэдгээр эрсдлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдал зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Мөн аудитын ажилд хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолуудын бодитой эсэхийг үнэлэх ажлууд багтана.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэй хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаархи санхүүгийн байдал хийгээд үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн, зөв, бодитой илэрхийлсэн байна.

Тайлан бичсэн захирал..... Т. Одончимэг

Зохиолчдын холбооны байр 314, 304 тоот Утас: 99069029, 96659029, 99065204, 99083284